**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2024/325/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2024 он | Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг<br>Утас:  261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: П.Чанцалдулам<br>Утас: 260512 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn<br>Аудитор: Д.Мөнхжин<br>Утас: 261628 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг Аудит  ХХК-ийн захирал : С.Тунгалаг<br>Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/309

танай ____________-ны № ____________-т

ЮНЕСКО-ГИЙН МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.БОЛДСАЙХАН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ЮНЕСКО-гийн монголын үндэсний комиссын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол ЮНЕСКО-гийн монголын үндэсний комиссын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс төлбөрийн и баримт болон нэхэмжлэхийн дүнгээс зөрүүтэй ажил гүйлгээг бүртгэсэн, төслийн зарцуулалтын дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, зарлагын баримтад төслийн дугаар бичээгүй зэрэг нийт 138,596.8 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 136,251.0 мянган төгрөгөөр давсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

ЮНЕСКО-гийн монголын үндэсний комисс нь тайлант хугацаанд нийт 29 төсөл хөтөлбөр хэрэгжүүлснээс 11 төсөл, хөтөлбөр нь 2024 онд хэрэгжиж дуусахаар байна.

**Аудитын гол асуудал**

Юнескогийн төлөөлөгчийн газраас хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

болох 650,859.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд бүртгэж, төсөл арга хэмжээтэй холбоотой 5,125.9 мянган төгрөгийн хангамж, бараа материалын зардал, 5,036.4 мянган төгрөгийн норматив зардал, 368,355.5 мянган төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 136,395.6 мянган төгрөгийн бараа үйлчилгээний бусад зардалд нийт 914,913.4 мянган төгрөгийг зарцуулж, 145,157.6 мянган төгрөгийн төвлөрүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Гадаад харилцааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас ЮНЕСКО-гийн монголын үндэсний комиссын 7 зорилтын хүрээнд 25 ажил, арга хэмжээг хэрэгжүүлсэн жилийн гүйцэтгэлийн тайлангийн гүйцэтгэлийг 88.44 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| ДАНС | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **317,413,343.84** | **170,969,601.03** |
| **31** | **МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ** | **-** | **-** |
| **33** | **АВЛАГА** | **158,130,440.17** | **145,207,566.11** |
| 33300 | Татаас санхүүжилтийн авлага | 158,130,440.17 | 145,157,583.41 |
| **335** | **Бусад авлага** | **-** | **49,982.70** |
| **3351** | **Байгууллагаас авах авлага** | **-** | **49,982.70** |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **135,540,905.00** | **-** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 135,540,905.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **23,741,998.67** | **25,762,034.92** |
| **354** | **Хангамжийн материал** | **23,741,998.67** | **25,762,034.92** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 662,700.00 | 564,950.00 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 397.00 | 272,641.25 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 23,078,901.67 | 24,924,443.67 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **76,698,554.21** | **57,219,109.28** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **76,698,554.21** | **57,219,109.28** |
| **392** | **Биет хөрөнгө** | **75,747,970.82** | **56,477,525.81** |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 55,000,000.00 | 55,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (1,833,333.34) | (12,833,333.38) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 15,940,930.00 | 15,940,930.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (6,196,713.22) | (11,427,195.70) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 9,879,323.50 | 9,879,323.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (832,527.98) | (3,330,815.63) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,613,071.00 | 3,613,071.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (90,279.14) | (631,953.98) |
| 39217 | Номын фонд | 267,500.00 | 267,500.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 950,583.39 | 741,583.47 |
| 39301 | Программ хангамж | 1,045,000.00 | 1,045,000.00 |
| 39302 | Хасагдуулаг | (94,416.61) | (303,416.53) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **394,111,898.05** | **228,188,710.31** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **158,130,440.17** | **251,328,034.93** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **158,130,440.17** | **251,328,034.93** |
| **413** | **Өглөг** | **158,130,440.17** | **251,328,034.93** |
| 41310 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | - | 371,486.48 |
| **4136** | **Бусад өглөг** | **158,130,440.17** | **250,956,548.45** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 158,130,440.17 | 250,956,189.95 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 358.50 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **235,981,457.88** | **(23,139,324.62)** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **235,981,457.88** | **(23,139,324.62)** |
| **511** | **Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан** | **78,398,015.00** | **78,398,015.00** |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 78,398,015.00 | 78,398,015.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **157,583,442.88** | **(101,537,339.62)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 157,583,442.88 | 157,583,442.88 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (259,120,782.50) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **394,111,898.05** | **228,188,710.31** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| ДАНС | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,054,887,635.13** | **749,756,591.56** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **882,113,135.13** | **267,378.25** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **882,113,135.13** | **267,378.25** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 5,100.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 5,100.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 71,226,673.50 | - |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | - | 267,378.25 |
| 120009 | Бусад орлого | 810,881,361.63 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **172,774,500.00** | **749,489,213.31** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **172,774,500.00** | **234,575,800.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 172,774,500.00 | 234,575,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **514,913,413.31** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | - | 505,701,413.31 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 9,212,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **977,733,796.15** | **1,008,877,374.06** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **977,733,796.15** | **1,008,877,374.06** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **956,047,466.08** | **978,635,337.78** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **120,484,653.08** | **157,205,538.98** |
| 210101 | Цалин | 90,033,526.10 | 104,751,694.55 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 11,326,649.37 | 23,967,681.23 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 17,546,021.21 | 16,382,500.00 |
| 210104 | Урамшуулал | 1,578,456.40 | 12,103,663.20 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **15,853,243.91** | **21,193,522.28** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 11,062,295.68 | 15,138,970.92 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 1,301,446.49 | 1,781,055.39 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 990,757.28 | 1,257,644.32 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 227,158.59 | 274,168.33 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 2,271,585.87 | 2,741,683.32 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **11,474,175.94** | **12,748,288.18** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | - | 1,373,088.18 |
| 210304 | Байрны түрээс | 11,474,175.94 | 11,375,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,872,873.53** | **6,870,098.68** |
| 210401 | Бичиг хэргийн материал | 4,981,028.00 | 2,784,270.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 2,761,003.23 | 1,110,700.00 |
| 210403 | Шуудан холбоо интернэтийн төлбөр | 4,130,842.30 | 2,975,128.68 |
| **2105** | **Норматив зардал** | **43,167,597.00** | **4,916,045.92** |
| 210502 | Хоол | 43,167,597.00 | 4,916,045.92 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж** | **509,196,661.47** | **608,154,829.91** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 507,742,164.47 | 605,508,329.91 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 1,100,000.00 | 2,646,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 160,740.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 156,857.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 36,900.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 243,998,261.15 | 167,547,013.83 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 238,376,421.49 | 148,067,568.90 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 5,621,839.66 | 19,479,444.93 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **21,686,330.07** | **30,242,036.28** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **21,686,330.07** | **30,242,036.28** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 21,686,330.07 | 30,242,036.28 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **77,153,838.98** | **(259,120,782.50)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)** | **77,153,838.98** | **(259,120,782.50)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| ДАНС | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,141,786,301.80** | **894,646,796.72** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **969,011,801.80** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **969,011,801.80** | **-** |
| 120009 | Бусад орлого | 969,011,801.80 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **172,774,500.00** | **894,646,796.72** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **172,774,500.00** | **234,575,800.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 172,774,500.00 | 234,575,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **660,070,996.72** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | - | 650,858,996.72 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 9,212,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **1,141,786,301.80** | **894,646,796.72** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,141,786,301.80** | **894,646,796.72** |
| **210** | **БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **961,969,531.56** | **719,247,177.03** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **120,484,653.08** | **157,205,538.98** |
| 210101 | Үндсэн цалин | 90,033,526.10 | 104,751,694.55 |
| 210102 | Нэмэгдэл | 11,326,649.37 | 23,967,681.23 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 17,546,021.21 | 16,382,500.00 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 1,578,456.40 | 12,103,663.20 |
| **2102** | **Ажил олгочоос нийтийн даатгалд төлөх шимтгэл** | **15,853,243.91** | **21,193,522.27** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 11,062,295.68 | 15,138,970.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 1,301,446.49 | 1,781,055.39 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 990,757.28 | 1,257,644.32 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 227,158.59 | 274,168.33 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 2,271,585.87 | 2,741,683.32 |
| **2103** | **Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал** | **11,461,675.94** | **12,748,288.18** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | - | 1,373,088.18 |
| 210304 | Байрны түрээс | 11,461,675.94 | 11,375,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **10,762,050.40** | **6,691,428.68** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,239,950.00 | 2,605,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,301,500.00 | 1,110,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,220,600.40 | 2,975,128.68 |
| **2105** | **Норматив зардал** | **45,218,073.63** | **5,036,346.00** |
| 210502 | Хоол, хүнс | 45,218,073.63 | 5,036,346.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **447,486,349.19** | **375,397,418.53** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 446,031,852.19 | 372,750,918.53 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,100,000.00 | 2,646,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 160,740.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 156,857.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 36,900.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **310,703,485.41** | **140,974,634.39** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 310,703,485.41 | 140,974,634.39 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **179,816,770.24** | **175,399,619.69** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **179,816,770.24** | **175,399,619.69** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 179,816,770.24 | 30,242,036.28 |
| 213305 | Үлдэгдэл төвлөрүүлэлт /нэмэлт/ | - | 145,157,583.41 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **-** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **-** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **78,398,015.00** | **80,429,603.90** | **158,827,618.90** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 78,398,015.00 | 80,429,603.90 | 158,827,618.90 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | - | - | - |
| Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | 77,153,838.98 | 77,153,838.98 |
| **2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **78,398,015.00** | **157,583,442.88** | **235,981,457.88** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 78,398,015.00 | 157,583,442.88 | 235,981,457.88 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | (259,120,782.50) | (259,120,782.50) |
| **2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **78,398,015.00** | **(101,537,339.62)** | **(23,139,324.62)** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|
| **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **234,575,800.00** | **204,333,763.72** | **30,242,036.28** | **87.1** |
| **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **234,575,800.00** | **204,333,763.72** | **30,242,036.28** | **87.1** |
| **Бараа, үйлчилгээний зардал** | **234,575,800.00** | **204,333,763.72** | **30,242,036.28** | **87.1** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **185,419,900.00** | **157,205,538.98** | **28,214,361.02** | **84.8** |
| Үндсэн цалин | 116,054,000.00 | 104,751,694.55 | 11,302,305.45 | 90.2 |
| Нэмэгдэл | 33,231,700.00 | 23,967,681.23 | 9,264,018.77 | 72.1 |
| Унаа, болон бусад нөхөн олговор | 23,100,000.00 | 16,382,500.00 | 6,717,500.00 | 70.9 |
| Урамшуулал | 13,034,200.00 | 12,103,663.20 | 930,536.80 | 92.9 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **23,177,200.00** | **21,193,522.27** | **1,983,677.73** | **91.4** |
| Тэтгэврийн даатгал | 15,760,700.00 | 15,138,970.91 | 621,729.09 | 96.1 |
| Тэтгэмжийн даатгал | 1,854,100.00 | 1,781,055.39 | 73,044.61 | 96.1 |
| ҮОМШӨ ний даатгал | 1,483,300.00 | 1,257,644.32 | 225,655.68 | 84.8 |
| Ажилгүйдлийн даатгал | 370,800.00 | 274,168.33 | 96,631.67 | 73.9 |
| Эрүүл мэндийн даатгал | 3,708,300.00 | 2,741,683.32 | 966,616.68 | 73.9 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **12,765,300.00** | **12,748,288.18** | **17,011.82** | **99.9** |
| Гэрэл цахилгаан | 1,528,100.00 | 1,373,088.18 | 155,011.82 | 89.9 |
| Байрны түрээс | 11,237,200.00 | 11,375,200.00 | (138,000.00) | 101.2 |
| **Хангамж, бараа материалын зардал** | **1,568,700.00** | **1,565,522.28** | **3,177.72** | **99.8** |
| Бичиг хэрэг | - | - | - | - |
| Тээвэр (шатахуун) | 1,110,700.00 | 1,110,700.00 | - | 100.0 |
| Шуудан  холбоо, интернэтийн төлбөр | 458,000.00 | 454,822.28 | 3,177.72 | 99.3 |
| Томилолт, зочны зардал | - | - | - | - |
| Дотоод албан томилолт | - | - | - | - |
| Зочин төлөөлөгч хүлээн авах | - | - | - | - |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **7,057,400.00** | **7,041,882.92** | **15,517.08** | **99.9** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,410,900.00 | 4,395,382.92 | 15,517.08 | 99.7 |
| Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 2,646,500.00 | 2,646,500.00 | - | 100.0 |
| Даатгалын үйлчилгээ | - | - | - | - |
| Тээврийн хэрэгслийн татвар | - | - | - | - |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | - | - | - | - |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 4,587,300.00 | 4,579,009.09 | 8,290.91 | 99.8 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 4,587,300.00 | 4,579,009.09 | 8,290.91 | 99.8 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **204,333,763.72** | **(204,333,763.72)** | **-** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **-** | **204,333,763.72** | **(204,333,763.72)** | **-** |
| Улсын төсвөөс санхүүжих | - | 204,333,763.72 | (204,333,763.72) | - |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** | **-** | **-** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | - |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **-** | **-** | **-** | **-** |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **-** | **-** | **-** | **-** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **9** | **9** | **-** | **100.0** |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 5 | 5 | - | 100.0 |
| Үйлчлэх ажилтан | 3 | 3 | - | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **514,913,413.31** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **-** | **514,913,413.31** |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | **-** | **514,913,413.31** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **-** | **-** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **-** | **-** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **-** | **-** |
| 210304 | Байрны түрээс | - | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **-** | **5,125,906.40** |
| 210401 | Бичиг хэрэг | - | 2,605,600.00 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | - | - |
| 210403 | Шуудан  холбоо, интернэтийн төлбөр | - | 2,520,306.40 |
| **2105** | **Нормативт зардал** | **-** | **5,036,346.00** |
| 210502 | Хоол, хүнс | - | 5,036,346.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **-** | **-** |
| 210702 | Дотоод албан томилолт | - | - |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **-** | **368,355,535.61** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 368,355,535.61 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | - | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | - | - |
| **2201** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **-** | **136,395,625.30** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 136,395,625.30 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **514,913,413.31** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **-** | **-** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | - | - |
| **14** | **БУСАД ЭХ ҮҮСВЭР** | **-** | **514,913,413.31** |
| 140020 | Бусад орлого | - | 514,913,413.31 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **-** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,054.5 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 2,054.5 сая төгрөгийн 13 алдааг залруууллаа.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

***/мянган төгрөгөөр/***

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланг бэлтгэхдээ нэмэлт санхүүжилтийн орлогыг бусад орлогоор тайлагнасан, төсвийн тохируулгын тайлан, хэлбэлзлийн тайланг бэлтгэж ирүүлээгүй; | 1 | - | 1 | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Шалгагдагч байгууллагын 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 91.4 мянган төгрөгийн орлогыг бараа материалын тодруулгад тайлагнаагүй; | 1 | 91.4 | 1 | 91.4 | - | - | 1 | 91.4 | - | - | - | - |
| Түрээсийн төлбөр болох 303.6 мянган төгрөгийн ажил гүйлгээг мөнгөн хөрөнгөөс шууд зардалд бүртгэснийг; | 1 | 303.6 | - | - | 1 | 303.6 | 1 | 303.6 | - | - | - | - |
| Нийгмийн даатгал, татварын байгууллагын тодорхойлолтоор өр авлагагүй боловч тус байгууллагын нэрээр өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэгдэж ирсэн 48,786.4 мянган төгрөгийн оны эцсийн үлдэгдлийг эрх бүхий байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулахгүйгээр өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлд сөрөг утгатайгаар бүртгэж, өглөгийг бууруулан тайлагнасныг; | 1 | 48,786.4 | - | - | 1 | 48,786.4 | 1 | 48,786.4 | - | - | - | - |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлд сөрөг утгатай бүртгэгдсэн нийгмийн даатгалын тайлангийн 27,260.8 мянган төгрөгийн, ХХОАТ-ын өр төлбөрийн 20,573.3 мянган төгрөгийн өр төлбөрийг холбогдох тайлангуудтай тулгахад нийт 47,834.1 мянган төгрөгөөр зөрүүтэйг; | 1 | 47,834.1 | - | - | 1 | 47,834.1 | 1 | 47,834.1 | - | - | - | - |
| Түрээсийн зардалд 66.0 мянган төгрөгийн принтерийн хорны зардлыг бүртгэж тайлагнасныг; | 1 | 66.0 | - | - | 1 | 66.0 | 1 | 66.0 | - | - | - | - |
| Анхан шатны баримтын бүрдэлгүй 15 удаагийн 2,811.7 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэж тайлагнасныг; | 1 | 2,811.7 | - | - | 1 | 2,811.7 | 1 | 2,811.7 | - | - | - | - |
| Шалгагдагч байгууллагын 6 байгууллагаас авах 963,914.7 мянган төгрөгийн, харилцагчийн нэр тодорхойгүй 3 байгууллагын 12,570.3 мянган төгрөгийн нийт 976,485.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг Юнеско-гийн МҮК-ын нэрээр 817,437.1 мянган төгрөгөөр, 5 байгууллагын авлагыг 917.5 мянган төгрөгөөр тус тус сөрөг утгатай бүртгэж авлагыг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр бууруулан авлагын үлдэгдлийг 158,130.4 мянган төгрөгөөр тайлагнасныг; | 1 | 818,354.6 | - | - | 1 | 818,354.6 | 1 | 818,354.6 | - | - | - | - |
| Нийт төсөл хэрэгжүүлэгч 9 харилцагчийн 145,207.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг харилцагч бүрээр дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, нийт дүнгээр бүртгэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүйг; | 1 | 145,207.6 | - | - | 1 | 145,207.6 | 1 | 145,207.6 | - | - | - | - |
| Өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлд 5 харилцагчийн өр төлбөрийн үлдэгдэл 818,354.6 мянган төгрөгийг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр сөрөг утгаар бууруулан тайлагнасныг; | 1 | 818,354.6 | - | - | 1 | 818,354.6 | 1 | 818,354.6 | - | - | - | - |
| Нийт 53 харилцагчийн 163,161.1 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүйг; | 1 | 163,161.1 | - | - | 1 | 163,161.1 | 1 | 163,161.1 | - | - | - | - |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцохдоо Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан элэгдлийн жилээс зөрүүтэй тооцсоноос 6,884.1 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг илүү тооцож бүртгэснийг; | 1 | 6,884.1 | - | - | 1 | 6,884.1 | 1 | 6,884.1 | - | - | - | - |
| Тайланд оны зардлаас 501,940.6 мянган төгрөг, өмнөх оны төслийн авлагаас 158,130.4 мянган төгрөг нийт 660,071.0 мянган төгрөгийг 29 төслийн зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан байна. Үүнээс: "Залуучуудын төсөл"-ийг 1,238.4 мянган төгрөгөөр, ТХЗ-4 тайлан боловсруулах төслийг 1,389.2 мянган төгрөгөөр тус тус батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулсан. | 1 | 2,627.6 | - | - | 1 | 2,627.6 | 1 | 2,627.6 | - | - | - | - |
| **Дүн** | **13** | **2,054,482.8** | **2** | **91.4** | **11** | **2,054,391.5** | **13** | **2,054,482.8** | **-** | **-** | **-** | **-** |

Аудитаар нийт 138.6 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 0.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1.7 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 136.7 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

***/мянган төгрөгөөр/***

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Нэмэлт санхүүжилтийн харилцах данснаас харилцагчид шилжүүлсэн 68,442.3 мянган төгрөгийн төлбөрийн баримтад санхүүжигч төслийн кодыг бүртгээгүй, төсөл хэрэгжүүлэгч тус бүр дээр дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй байна. | 1 | 68,442.3 | - | - | - | - | 1.0 | 68,442.3 | - | - | - | - |
| Үндсэн үйл ажиллагаатай холбоотой оффисын цэвэрлэгээний зардал 320.0 мянган төгрөг, аудитын төлбөр 353.5 мянган төгрөг, автотээврийн хэрэгслийн татвар 201.9 мянган төгрөг, түрээсийн зардал 2,320.0 нийт 1,296.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас шилжүүлсэн байна. | 1 | 3,195.3 | - | - | - | - | 1.0 | 3,195.3 | - | - | - | - |
| Төсөл хэрэгжүүлэгч хувь хүнтэй байгуулсан гэрээний дунд НДШ, ХХОАТ-ыг оруулаагүйн улмаас, Нэмэлт санхүүжилтийн дансны төсөл хөтөлбөрийн зардлаас 21,243.1 мянган төгрөгийн НДШ-ийн зардал, 8,200.6 мянган төгрөгийн ХХОАТ нийт | 1 | 29,443.7 | - | - | - | - | 1.0 | 29,443.7 | - | - | - | - |

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 29,443.7 мянган төгрөгийн төсөвт батлагдаагүй зардлыг санхүүжүүлсэн байна. | | | | | | | | | | | | |
| Худалдан авсан хөрөнгө, материалын дүн, бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн цахим баримтын дүнгээс 8 иргэн, байгууллага 19,4387,7 мянган төгрөгөөр илүү, 33 иргэн байгууллага 16,222.8 мянган төгрөгөөр дутуу дүнгээр бүртгэгдсэн байна. | 1 | 35,661.5 | - | - | - | - | 1.0 | 35,661.5 | - | - | - | - |
| Тайлант онд 3 ажилтны томилолтоор ажиллах хугацаанд 120.0 мянган төгрөгийн хоол, унааны мөнгийг давхардуулан олгосон байна. | 1 | 120.0 | 1 | 120.0 | - | - | | | - | - | - | - |
| Ээлжийн амралтын олговрыг давтан тооцоолоход 2 ажилтны дундаж цалин хөлсийг 15,19 сарын цалингийн дунджаар тооцсоноос ээлжийн амралтын олговрыг 98.1 мянган төгрөгөөр дутуу бодож олгосон байна. | 1 | 98.1 | - | - | 1 | 98.1 | | | - | - | - | - |
| Албан томилолтын зардлыг анхан шатны баримттай тулган шалгахад 1 ажилтанд 1 өдрийн гадаад томилолтын зардлыг 931.9 мянган төгрөгөөр илүү олгосон байна. | 1 | 931.9 | - | - | 1 | 931.9 | | | - | - | - | - |
| Тайлант оны Шатахуун зарцуулалтын тайланг давтан тооцоолоход нийт 247.94 л 704.1 мянган төгрөгийн шатахууныг илүү тооцож олгосон байна. | 1 | 704.1 | - | - | 1 | 704.1 | | | - | - | - | - |
| **Дүн** | **8** | **138,596.8** | **1** | **120.0** | **3** | **1,734.1** | **4** | **136,742.7** | **-** | **-** | **-** | **-** |

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 11.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 11.8 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| Тайлант оны шилэн дансны цахим хуудсыг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа оруулсан 71, оруулах мэдээлэл байхгүй 93, хугацаа хоцроож зассан 7 мэдээлэл байна. Шилэн дансанд мэдээлсэн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг Мөнгөн гүйлгээний журналын орлого, зарлагын дүнтэй тулгахад 16 удаагийн гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | - | 1 | - | - | - |
| **Дүн** | **1** | **-** | **1** | **-** | **-** | **-** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| Тайлант онд нийт 1,528.1 мянган төгрөгийн ЦЭХ зарцуулахаар баталснаас 1,373.1 мянган төгрөгийн цахилгаан эрчим хүчийг зарцуулсан ба батлагдсан төсвөөс, 420.7 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулж батлагдсан төсвийг 265.7 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. | 1 | 265.7 | 1 | 265.7 | | |
| Тайлант онд шалгагдагч байгууллагаас зохион байгуулсан 1 удаагийн танхимын 36 ажилтныг хамруулж 11,548.1 мянган төгрөгийн зардал гаргасан байна. | 1 | 11,548.1 | 1 | 11,548.1 | | |
| **Дүн** | **2** | **11,813.7** | **2** | **11,813.7** | **-** | **-** |
| **Нийт дүн** | **3** | **11,813.7** | **3** | **11,813.7** | **-** | **-** |